

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.1. Төслийн тухай товч танилцуулга	2
1.2. Төслийн зорилго	2
1.3. Уурхайн байршил	2
1.4. Төслийн хүчин чадал	4
1.5. Ордыг ашиглах технологийн сонголт	4
1.5.1. Ил уурхайн олборлолт	4
2. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	5
3. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт	6
4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	9
5. хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	11
6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	12
7. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	14
8. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	14
9. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	14
10. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	14
11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	15
12. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	16
13. Аймаг, сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	16
14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА	17

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн тухай товч танилцуулга

Төслийн нэр: Баруун цагаан дэлийн “Жонш Толгойн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах” төсөл

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: “Экилешия” ХХК

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-014111

ААН улсын бүртгэлийн дугаар: 9011254020

Регистерийн дугаар: 5411726

Хаяг: Улаанбаатар хот, ХУД, 15-р хороо, Их
Наяд Зүүн Өндөр 1304 тоот

Холбоо барих утас: 99275568

1.2. Төслийн зорилго


Уурхайн үндсэн зорилго нь байгалийн баялгийг ашиглахад чиглэсэн бөгөөд нөлөөлөл нь мөн шууд, буцалтгүй шинжтэй болно. Иймд Монгол улсын Газрын хэвлийн хууль, Ашигт малтмалын хууль, Байгаль хамгаалах хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, байгалийн баялгийг алдагдал хаягдалгүй бүрэн ашиглах, байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг жил бүр уурхай, санхүүгийн төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжүүлж ажилах болно.

1.3. Уурхайн байршил


Баруун Цагаан дэлийн “Жонш Толгойн” хайлуур жоншны орд нь Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэрт оршино. Улаанбаатар хотоос зүүн урагш 320 орчим км, Дорноговь аймгийн Айраг сумаас баруун урагш 23 орчим км зайтай байрлана. Ашиглалтын MV-014111 тоот тусгай зөвшөөрөл бүхий Жоншт толгойн хайлуур жоншны ордын 1, 2, 3-р хүдрийн биетийн талбай хэмжээ 38.0 га бөгөөд дараах газар зүйн солбилцлоор хязгаарлагдана.

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн солбилцол

№	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек
1	109	7	26.72	45	40	26.61
2	109	7	26.72	45	40	9.61
3	109	7	51.72	45	40	9.61
4	109	7	51.72	45	40	1.62
5	109	7	11.72	45	40	1.62
6	109	7	11.72	45	40	26.61



Зураг 1. Төслийн талбайн байрзүйн зураг



Зураг 2. Төслийн талбайн байршил

1.4. Төслийн хүчин чадал

Уурхайн хүчин чадал нь 2025 онд 22 мян.т жоншны хүдэр олборлохоор байна. Уурхай нь өвлийн улиралд улирлын зогсолт хийж 5-11 сард (жилд 154 хоног) ажиллана.

1.5. Ордыг ашиглах технологийн сонголт

Төслийн техник эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-д тусгаснаар ордын хайлуур жоншны судал нь 700 уналтай, зузаан нь дунджаар 3.92 м байна. Газрын гадаргатай ойрхон судалтай өмнө нь ил аргаар ашиглаж байсан учир авто тээвэртэй ил аргаар ашиглахад тохиромжтой байна.

1.5.1. Ил уурхайн олборлолт

Ордын хайлуур жоншны судал нь 70° уналтай, зузаан нь дунджаар 3.92 м байна. Газрын гадаргатай ойрхон судалтай өмнө нь ил аргаар ашиглаж байсан учир авто тээвэртэй ил аргаар ашиглах тохиромжтой гэж үзлээ.

Хүснэгт 2. Ашиглалтын систем

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Авто тээвэртэй ашиглалтын технологи	Хөрс хуулалт	Тэсэлгээ хийх
		Ухаж ачих
		Тээвэрлэх
		Гадаад овоолго
	Хүдэр олборлолт	Тэсэлгээ хийх
		Ухаж ачих
		Тээвэрлэх

Жоншт толгойн ордын нөөцийг аль болох бүрэн ашиглах зорилгоор захиалагч талд бэлэн байгаа тоног төхөөрөмж, уурхайн орлын өргөн болон ажлын хамгийн бага талбайгаас хамааран загварчилахад 62841 тонн хүдэр олборлон, 1947.15 тонн хүдэр хүрээ хязгаараар хязгаарлагдаж байхаар төсөлд тусган байна. Жоншт толгойн 1, 2, 3-р хүдрийн биетүүдийн хайлуур жоншны ил уурхайн хил хязгаарыг нийт В зэрэглэлийн нөөцийг ашиглах хүрээнд дараах байдлаар явуулахаар тогтоов. Уурхайн дундаж гүн 29м, урт 127м, өргөн 25м бөгөөд уурхайн талбайн хэмжээ 1.35 га байхаар төлөвлөж байна.

Ил уурхайн хил хүрээг сонгохдоо ордын нөөцийг иж бүрэн ашиглах боломж, уурхайн хүчин чадал, аюулгүй ажиллагааны шаардлага, байгаль орчны нөхөн сэргээлтийн хэтийн төлөв байдал, эдийн засгийн хувьд хамгийн бага зардлаар ашиглах нөхцөл зэргүүдийг харгалзан үзлээ. Мөн II-р бүлгийн орд тул В нөөцөнд тулгуурлан нөөцийн тооцоог хийсэн байна.

2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Уурхайн талбай нь Дорноговь аймгийн Айраг сумын 1-р багийн нутаг, Айраг сумын төвөөс баруун урагш 23 км зайд байрлана. Тус төслийг хэрэгжүүлэхэд хүрээлэн буй орчинд учирч болзошгүй нөлөөллийг тодорхойлсон үр дүнд үндэслэн нөлөөллийн эх үүсвэр, шинж чанарыг тодорхойлж дараах хүснэгтэд үзүүлэв. Өмнө нь хийгдсэн болзошгүй нөлөөллийн судалгааны дүнгээс үзвэл тус төслөөс байгаль орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь:

Хүснэгт 3. Болзошгүй сөрөг нөлөөлөл ба эх үүсвэр

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа)	Нөлөөллийн шинж чанар
<i>Агаар орчин</i>			
1	Тоосжилт (PM _{2.5} PM ₁₀)	-Ажилчдын хөл хөдөлгөөн -Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн -Гадаад, дотоод тээвэр -Үржил шимт хөрсний овоолго	-Тархах хүрээ хязгаарлагдмал -Салхины хурд бриксийн хурдаас давах, агаарын температур их үед үүснэ.
2	Хийн хаягдал (Утаа, Угаар, SO, NO, CO)	-Тээврийн хэрэгсэл, машин механизмын хөдөлгүүр	-Агаарыг бохирдуулах боловч хадгалагдах болон тархах хүрээ хязгаарлагдмал
<i>Усан орчин</i>			
3	Усны нөөцийн хомсдол	-Унд ахуйн усны хэрэглээ	-Ажилчдын унд-ахуйн усны хэрэглээг Айраг сумын төвд гүний худгаас хангана.
4	Хатуу болон шингэн хаягдал	-Ахуйн хог хаягдал -Шатах тослох материалын хаягдал	-Газрын ус бохирдох бусад эх үүсвэрүүд -Газрын доорх усны бохирдолд өртөгдөх байдал -Удаан сарнина -Гадаргын хэлбэрши
<i>Хөрсөн бүрхэвч</i>			
5	Элэгдэл, эвдрэл	-Уурхайн олборлолт -Гадаад, дотоод тээвэр	-Тархалтыг хязгаарлах боломжтой -Нөхөн сэргээх боломжтой
6	Бохирдол	-Ахуйн хог хаягдал -Шингэн хаягдал -ШТМ-ын асгаралт	-Тархах хүрээ хязгаарлагдмал -Хөрс бохирдсоноос хөрсний микробиологийн шинж чанар алдагдана. Хөрсний бохирдол шингээх хурд
<i>Ургамлан бүрхэвч</i>			
7	Ургамлан нөмрөг талхлагдах	-Уурхайн олборлолт -Уурхайн тээврийн зам	-Хэмжээ хязгаарлагдмал -Ургамлын төрөл зүйл устах -Ногоон байгууламж, тарималжуулалт хийснээр нөхөн сэргээх боломжтой
<i>Нийгэм-эдийн засгийн орчин</i>			
8	Ажилчид	-Хүн амын эрүүл мэнд, ажил эрхлэх чадавх дээшилнэ	-Хүн амын эрүүл мэндэд эерэг нөлөө их
9	Үндсэн хөрөнгө	-Татварын эх үүсвэр	-Улсын төсөвт хувь нэмэр оруулна
10	Шинэ ажиллагсад	-Ажлын байр бий болно	-Орон нутгийн иргэд орлогын тогтмол эх үүсвэртэй болно

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчин бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах үндсэн зорилготой.

Тус төслийн БОННУ-д тусгасан Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төслийн үйл ажиллагаатай холбогдох байгаль орчныг хамгаалах хууль, эрхзүйн орчин, төслийг хэрэгжүүлэх явцад зайлшгүй мөрдөж ажиллах хуулийн хориглосон, хязгаарласан зүйл, заалтууд, төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, стандарт, Монгол Улсын нэгдэн орсон конвенциудын холбогдох шаардлагуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, тэдгээр эрх зүйн баримт бичгүүдийг мөрдлөг болгон ажиллана.

Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй гэнэтийн осол эрсдэлээс урьдчилан сэргийлж, хүрээлэн буй орчин болоод нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж болох бүх талын арга хэмжээг авч эрүүл аюулгүй, байгальд ээлтэй технологийг нэвтрүүлж ажиллана. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний хүрээнд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн хамарсан.

Тус төлөвлөгөө нь тухайн төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны орон зай, цаг хугацааг бүрэн хамарсан байхаас гадна байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлтийн арга хэмжээ зэрэг төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардал, хариуцан гүйцэтгэх эзэн, хэрэгжүүлэх хугацаа ба давтамжийг бодитойгоор тооцож тусгасан. Тухайн жилийн БОМТ-ний нийт төсөвт 20,1 сая.төг зарцуулахаар төлөвлөсөн.

2024 оны БОМТ-ний биелэлтийг орон нутгаас томилогдсон ажлын хэсэгт 2025 оны 6-р сарын 10-ны өдөр 90.9%-тай дүгнэгдсэн. Иймд 2025 оны БОМТ-нд орон нутгаас өгсөн саналын дагуу дараах ажлуудыг оруулав.

Хүснэгт 4. Орон нутгийн ажлын хэсгийн санал

№	Орон нутгаас өгсөн санал	Орон нутгаас өгсөн саналын дагуу хэрэгжүүлэх ажлууд
1	“Тэр бум мод тарих” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцох тайлан мэдээг ирүүлэх	2024 онд 500ш мод Айраг суманд тарьж ургуулсан.
2	Орчны хяналт шинжилгээг тогтмол бүрэн хийлгэхэд анхаарч, хяналт тавин дүн шинжилгээ хийх	ОХШХ-т тусгасан
3	Ундны усны шинжилгээг улирал тутам өгөх	ОХШХ-т тусгасан
4	Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах, ус ашиглалтын тайланг тайлант онд багтаан ирүүлэх	Унд ахуйн усыг Айраг сумын гүний худгаас худалдан авдаг ба уурхайн шүүрлийн усанд тоолуур суурьлуулахаар төлөвлөв.
5	Хог хаягдлын цэгийг хуульд заасан шаардлагын дагуу байгуулах	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгав
6	Аюултай хог хаягдлаа /химийн бодисын сав, баглаа, боодол/ хуульд заасан хугацаанаас хэтрүүлж хадгалахгүй байх	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгав
	Аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх	Аюултай хог хаягдал болох уурхайд ашиглагдах тээврийн хэрэгслээс гарах тос маслыг хэлнэ. 2025 онд ашигласан тос маслийг “Клийн Ойл” ХХК-тай гэрээлэхээр төлөвлөв.
7	Аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад шилжүүлэх хүртэл түр аюулгүй нөхцөлийг бүрдүүлсэн орчинд, хуулийн хугацаанд хадгалах	2025 онд аюултай хог хаягдал хадгалах түр цэгийг байгуулахаар төлөвлөв.
8	Тээврийн жолооч нарын байгаль хамгаалах үүрэг хариуцлагыг сайжруулах, ил задгай хог хаях, зориулалтын бус газар засвар үйлчилгээ хийх, маршрутын бус замаар тээвэр хийлгэхгүй байхад анхаарах	Тээврийн жолооч нарыг батлагдсан маршрутаар явах, ил задгай хог хаяхгүй байх болон зориулалтын бус газар засвар үйлчилгээ хийлгэхгүй байх шаардлагыг уурхайн ХАБЭА ажилтан тогтмол тавьна.
9	Ан амьтдын байршил, тархалт тоо толгойг тогтоон төслийн үйл ажиллагаанаас учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг орон нутгийн Засаг захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх	Энэхүү саналын хүрээнд орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтран ажиллах санал дэвшүүлнэ.
10	Уул уурхайн үйлдвэрийн бүс дотор болон төвийн цахилгаан шугамаас уурхайн чиглэлд татсан өндөр	Төвийн цахилгаан шугамнаас уурхайн чиглэлийн цахилгаан шугамд 3ш

	хүчдэлийн цахилгаан шон дагуу шувуу үргээгч байршуулах	шувуу үргээгч байршуулахаар төлөвлөв.
11	Байгаль орчин хамгаалах тухай хуулийн 10.1-д заасны дагуу Байгаль орчны аудитыг хуулийн хугацаанд хийлгэн зөвлөмжийн биелэлтийг ирүүлэх	2025 онд байгаль орчны аудитыг хийлгэнэ.
12	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.1.6 заалтын дагуу Экологийн паспорт хөтлөх MNS 4219-94	2025 оны БОМТөлөвлөгөөний удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан.
13	Төлөвлөгөөнд заасан арга хэмжээг тайлагнахдаа арга хэмжээний цар хүрээ, хугацаа, тоо, чанарыг тодорхой, дэлгэрэнгүй оруулах	2025 оны БОМТ-ний биелэлтийг тайлагнахдаа анхаарах.
14	Өнгөрсөн онуудад өгсөн зөвлөмж чиглэлийг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлээгүй байгаад онцгой анхаарч хэрэгжүүлж ажиллах	Өмнөх онуудад өгсөн зөвлөмж чиглэлийг төлөвлөгөөнд тусган ажилладаг.
15	Нөлөөллийн бүсийн оршин суугч, иргэдэд төслийн үйл ажиллагаа болон байгаль орчны чиглэлээр хийгдсэн ажлыг ил тод, нээлттэй танилцуулж байхыг мэдэгдье.	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад 4-р улиралд өвс тэжээл олгох үед БОМТ биелэлтийн тайланг танилцуулан ажилладаг.

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаар						
1	Тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас тоосжилт үүсэх.	Цаг агаарын урьдчилсан мэдээг үндэслэн тоосжилтыг бууруудах төлөвлөгөөт усалгааны хуваарь гаргах	БО мэргэжилтэн боловсруулна.	-	Хуурайшилттай үед	MNS 5014:2003 MNS5010-2001, “ХААЭА. Ажлын байран дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага”
2		Тоосжилтыг дарах уурхайн замын усаглгаа хийх	Уурхайн бүс, зам талбай	500,000	Хуваарийн дагуу	MNS:4596:2007 Замын тэмдэг, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх журам
3	Утаа болон хийн бохирдол үүсэх	Агаарын бохирдлын тухай хуулийн дагуу техник хэрэгслийн татварыг төлөх	Хүнд даацын машин механизм	100,000	Төсөл хэрэгжих хугацаанд	
Хөрс, газрын гадрага						

1	Уурхайн ашиглалтын явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал тоосжилтоос бохирдол	Хог хаягдлыг тээвэрлэж зайлуулна.	Орон нутагтай хамтран гэрээгээр зайлуулна.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.	Орон нутагтай хийсэн гэрээний дагуу	-Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, -MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2	үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам	ШТМ-ын хадгалалтад хяналт тавина.	ШТМ хадгалах цэгт	ҮАЗ		
3	гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх, ШТМ, барилгын материалын хог хаягдал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	Уурхайн орчны олон салаа зам гаргахаас сэргийлж нэгдсэн нэг замаар зорчиход жолооч нарт шаардлага тавих.	Уурхайн тээврийн зам	ҮАЗ		
4	ТХ-ийн явах эд ангиуд гэмтэх, ШТМ асгарсан тохиолдолд тухайн орчмын хөрсөн бүрхэвчийг бохирдуулж болзошгүй	Уурхайн авто зогсоол болон кемп орчмын тосоор бохирдсон хөрсийг цэвэрлэх.	Уурхайн авто зогсоол, кемп	ҮАЗ		
Усан орчин						
1	Ус ашиглах боломжит нөөцийн тооцоонд тусгагдсаны дагуу ариг гамтай ашиглах	Уурхайгаас гарах шүүрлийн усыг уурхайн урд байрлах нуурлуу татан зайлуулж байгаа хэмжээг хянах зорилгоор тоолуур суурилуулна.	Шүүрлийн усыг татан зайлуулах цэгт	800,000	4-р сард	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль -ЗГ-ын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралт-Ус ашигласны төлбөрийн хувь хэмжээ.
2		Харъяа байгууллагатай ус ашиглах гэрээ	Гэрээний дүнгээр		2025 он	

		байгуулах, төлбөр төлөх				
Ургамал						
1	Уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөр ургамлан нөмрөг устгах	Уурхайн тээврийн зам дагуу ургамлын аймгийг тодорхойлох цэгт ургамлын мониторинг хийх	Тээврийн зам	300,000	6 сараас 9 сарын хооронд	Ургамлын мониторинг хийх аргачлал (шугаман цэгийн арга)
Нийт зардал:				3,400,000		

5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог ангилал	Хаягдлын	Сөрөн нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нийт зардал	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ахуйн	Ахуйн хог хаягдлыг орон нутгаас заасан цэгт тээвэрлэн зайлуулах	Уурхайгаас гарах хатуу хог хаягдал Гэрээний дүнгээр				Хог хаягдлын тухай хууль, ангилан ялгаж хаях журам, дотоод дүрэм журам
	Хог хаягдлын гэрээ байгуулах, төлбөр хураамжийг цаг тухайд нь төлөх					
	Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах	Хуванцар Ахуйн Аюултай	ҮАЗ			
	Хог түр хадгалах цэг байгуулах	Уурхайгаас үүсэх хог хаягдал	1,000,000			

Аюултай	Ашигласан тос маслыг мэргэжлийн байгуулгатай гэрээ хийж зайлуулах /Клийн Ойл ХХК/	ШТМ хадгалах цэг	Гэрээний дүнгээр	
Нийт			2,500,000	

6. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Уурхайн үйл ажиллагааны явц дахь гэнтийн осол	Анхны тусламжийн иж бүрдэл хүрэлцээтэй хэмжээгээр бэлтгэх	Уурхайн бүс	300,000	2025 он	-
2		ХАБЭА-н сургалтуудыг тогтмол зохион байгуулах		300,000	Жилд 1 удаа	
3		Уурхайн тэмдэг тэмдэглэгээг хэрэгцээт хэмжээгээр байрлуулах		250,000	2025 он	
4		Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх		ҮАЗ	Өдөр бүр	

4	Болзошгүй гал түймэр	Гал түймрээс урьдчилан сэргийлэх хэрэгсэл (галын дохиолол, хүрз, элс, хөөс, аюулгүй байдлын самбар) болон гал гарсан тохиолдолд унтраах, хамгаалалтын багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулаж, дууссан тохиолдолд цэнэглүүлэх		800,000	2025 он	Гамшгаас хамгаалах тухай хууль
5		Галын дүгнэлтийг мэргэжлийн байгуулгаар гаргуулах		100,000		Галын аюулгүй байдлын тухай хууль
Нийт зардал:				1,980,000		

7. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 онд уурхайд дотоод техникийн нөхөн сэргээлт төлөвлөхгүй.

8. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хувилбар	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Зардал /төг/	Хэрэгжүүлэгч	Баримтлах хууль, журам, стандарт
1	1	Уурхайн урд байрлах байгалийн тогтоц нуурыг тэжээх зорилгоор уурхайгаас гарах шүүрлийн усыг шуудуу болон зам огтлолцож байгаа хэсгийн доогуур турба татаж тус нуурлуу нийлүүлж ан амьтан ундаалах нөхцлөөр хангаж өгнө.	Уурхайн урд 1.3км зайд байрлах нуур	6,000,000	“Экилешия” ХХК	
2	2	Уурхайгаас гарах шүүрлийн усаар нөлөөллийн бүсийн оршин суугчдын тэжээл тарих талбайг услах болон талбайг хашаалах	Уурхайн урд байрлах тэжээл тарих талбай	6,000,000	“Экилешия” ХХК	
Нийт зардал				6,000,000		

9. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаагаар газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх ажил явагдахгүй.

10. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ тус онд явагдахгүй.

11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хяналт- шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Зардал төг /жил	Баримтлах стандарт ба арга аргачлал
Агаарын чанар				
Агаарын бохирдлын цэгэн эх үүсвэр: TPS, PM2.5,PM10, SO2, NO2	-Уурхайн суурин -Тээврийн зам -Овоолго орчим -Уурхайн олборлолт явуулах цэг орчим	Жилд 2 удаа	520,000	Дээжлэхдээ MNS 4585:2007, MNS:3384:1982 MNS:4048:1988–г баримтлах
Гадаргын болон газрын доорхи ус				
Усны чанар: рН, TDS, нийт хатуулаг, ууссан хүчилтөрөгч, БХХ, ХХХ, Са, Mg, Na, K, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ , As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni,	Ундны ус	Жилд 2 удаа	360,000	MNS (ISO) 5667- 5:2001- усны чанар- дээжлэлт
Ахуйн бохир усны цоонгийн бохир ус: рН, Ж/б, ХХХ, БХХ, NH ₄ , NO ₂ , NO ₃ , N-нийт, P-эрд	Ахуйн бохир ус	Жилд 1 удаа	900,000	MNS (ISO) 5667- 10:2001 “Усны чанар.дээж авах. 10-р бүлэг. Хаягдал уснаас дээж авах заавар”
Хөрсөн бүрхэвч				
Хөрсний бохирдол, ялзмагийн агууламж: рН,, чийгшил, ялзмаг, NH ₄ , NO ₃ , SO ₄ , P ₂ O ₅	Уурхайн карьер Хөндөөгүй газар Тээврийн зам дагуу Уурхайн суурин	Жилд 2 удаа	611,000	MNS3298-90 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS5850:2008
Хөрсөнд агуулагдах хүнд металлын агууламж: Ni, Cd, Pb, Cu, Zn, Cr	Авто зогсоол Засварын газар Тээврийн зам дагуу	Жилд 2 удаа	40,000	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Нийт зардал:			2,531,000 төг	

12. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжүүлэх хуваарь	Зардал /төг/	Хариуцсан албан тушаалтан
1	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.1.6 заалтын дагуу Экологийн паспорт хөтлөх MNS 4219-94	-		Байгаль орчны мэргэжилтэн
2	Уурхайн нийт ажилчдыг гэнтийн ослын даатгалд хамруулах	2-р улиралд багтаан гэрээ хийх	2,500,000	Хүний нөөцийн мэргэжилтэн
Нийт зардал			3,500,000	


13. АЙМАГ, СУМЫН ОРОН НУТГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ШААРДЛАГААР ХИЙСЭН АЖИЛ БОЛОН НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОМТ-ийн хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцсан зохион байгуулах ажилтан
1	БОУАӨЯ-д	Цахим хэлбэрээр	2025 оны БОМТ-ний биелэлтийн хүрээнд хийсэн ажил	2025 оны 4-р улирал	-	Байгаль орчны мэргэжилтэн
2	Орон нутгийн байгаль орчны байцаагч болон засаг дарга	Бичгэн тайлан		2025 оны 4-р улирал	100,000	Байгаль орчны мэргэжилтэн
3	Аймгийн байгаль орчны газарт	Шинжээчийн дүнгээр баталгаажна		2025 оны 4-р улирал	100,000	Байгаль орчны мэргэжилтэн
Нийт зардал				200,000		

14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний задаргаа	Зардал
1	Сөрөг нөлөөллийн буруулах арга хэмжээ	3,400,000
2	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2,500,000
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,980,000
4	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
5	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	6,000,000
6	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
7	Түүх соелын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2,531,000
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	3,500,000
10	Аймаг, сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	200,000
Нийт		20,111,000 төг

Зураг 3. Уурхайн шүүрлийн усыг нуурлуу шавхан зайлуулах маршрут



Зураг 4. Шүүрлийн ус шавхан зайлуулах нуурын харагдах байдал

